



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2016 оны 6 дугаар сар


Ерөнхий тойм: Оны эхний 6 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 12.3%-иар буюу 516.9 сая ам.доллараар буурч 3692.0 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 7.5%-иар буюу 177.3 сая ам.доллараар, импорт 18.5%-иар буюу 339.6 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 693.8 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 162.3 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 6 сараар			Өөрчлөлт			
	2013	2014	2015	2014/2013		2015/2014		2014	2015	2016	2015/2014		2016/2015	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,627	11,011	8,467	384	3.6%	(2,545)	-23.1%	5,118	4,209	3,692	(909)	-17.8%	(517)	-12.3%
Экспорт	4,269	5,775	4,669	1,506	35.3%	(1,105)	-19.1%	2,481	2,370	2,193	(111)	-4.5%	(177)	-7.5%
Импорт	6,358	5,237	3,797	(1,121)	-17.6%	(1,439)	-27.5%	2,637	1,839	1,499	(798)	-30.3%	(340)	-18.5%
Тэнцэл	(2,089)	538	872	2,627		334	62.2%	(156)	531	694	688		162	30.5%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлтүүдийн нэг юм. 2010 оноос хойш тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны сүүлийн хагасаас ашигтай гарч эхэлсэн. Уг үзүүлэлт 2016 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 729.2 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 78.8 сая ам.доллараар өссөн байна.

Дүрслэл 1. Валютын төлбөртэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Дүрслэл 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 61.8% буюу 2283.5 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 10.6% буюу 389.9 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 15.3%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 25.8%-иар тус тус буурсан байна.

Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Хүснэгт 2. Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

Үнийн индексийн төрөл*	2015.6 сар	2016.5 сар	2016.6 сар	Жил Δ	Сар Δ
Экспорт	1.05	0.77	0.72	-32%	-6%
Зэсийн баяжмал	0.58	0.37	0.37	-36%	0%
Чулуун нүүрс	0.57	0.41	0.41	-28%	0%
Ямааны угаасан ноолуур	0.44	0.36	0.36	-18%	0%
Импорт	0.61	0.56	0.56	-9%	1%
Хэрэглээний бараа	0.76	0.76	0.77	0%	1%
Хөрөнгө оруулалтын бараа	0.52	0.49	0.50	-3%	1%
Нефтийн бүтээгдэхүүн	0.63	0.44	0.47	-26%	5%
Худалдааны нөхцөл	1.72	1.38	1.29	-25%	-7%

* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 25.1%-иар, өмнөх сараас 6.8%-иар тус тус буурч 1.289-д хүрлээ. Тайлант сард голлох импортын үнэ өссөн, зэсийн баяжмал, чулуун нүүрсний экспортын үнэ буурснаас худалдааны нөхцөл өмнөх сараас буурсан байна.

Экспортын гадаад худалдаа 2016 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 7.5%-иар буюу 177.3 сая ам.доллараар буурсан. Экспортын бууралтыг ерөнхий ангиллаар задалбал аж үйлдвэрлэл, мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортыг 0.6%-иар өсөхөд нөлөөлсөн ч, уул уурхайн түүхий эдийн экспортын бууралт нь нийт экспортыг 7.6%-иар буурахад нөлөөлжээ. Улмаар уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 1 нэгж хувиар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 1 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Экспортын гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%2	Дүн	Өсөлт	%2
1. Уул уурхай		2,152	87%	2,060	87%	1,880	86%	(93)	-4%	-4%	(180)	-9%	-8%		
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	583	985	40%	664	1,147	48%	821	920	42%	162	16%	7%	(227)	-20%	-10%
1.2. Чулуун нүүрс	9,348	451	18%	6,856	309	13%	9,678	295	13%	(142)	-32%	-6%	(13)	-4%	-1%
1.3. Боловсруулагүй нефть	3,193	320	13%	3,771	197	8%	4,179	160	7%	(123)	-39%	-5%	(37)	-19%	-2%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	2,598	208	8%	2,272	115	5%	2,587	98	4%	(94)	-45%	-4%	(16)	-14%	-1%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	2,172	90	4%	4,014	158	7%	7,074	280	13%	68	76%	3%	122	77%	5%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	45	48	2%	56	71	3%	68	72	3%	22	46%	1%	1	2%	0%
1.7. Жоңц, лейцит, нефелинт	138	30	1%	138	32	1%	119	27	1%	1	5%	0%	(4)	-14%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	13	1%	2	18	1%	3	12	1%	5	40%	0%	(6)	-34%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	4	0%	1	5	0%	1	4	0%	1	18%	0%	(1)	-23%	0%
1.10. Мөнгө /тонн/	3	0	0%	27	7	0%	22	9	0%	7	0%	0%	2	22%	0%
1.11. Бусад	10	1	0%	46	1	0%	46	1	0%	0	50%	0%	(0)		0%
2. Мал аж ахуй		241	10%	187	8%	190	9%	(55)	-23%	-2%	4	2%	0.2%		
2.1. Амьд мал, малын мах	1	1	0%	2	6	0%	2	5	0%	5	372%	0%	(1)	-13%	0%
2.2. Арьс, шир	186	23	1%	154	18	1%	103	17	1%	(5)	-23%	0%	(1)	-6%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	5	0%	0	5	0%	0	4	0%	0	7%	0%	(1)	-25%	0%
2.4. Ноолуур	5	207	8%	4	150	6%	5	156	7%	(57)	-27%	-2%	6	4%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	4	6	0%	5	8	0%	5	8	0%	2	39%	0%	0	1%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	76%	0%	0	265%	0%
3. Газар тариалан		14	1%	21	1%	11	1%	7	46%	0%	(10)	-46%	0%		
4. Аж үйлдвэрлэл		72	3%	101	4%	111	5%	30	41%	1%	10	10%	0.4%		
4.1. Хүнс	0	2	0%	2	15	1%	3	16	1%	13	651%	1%	1	10%	0%
4.2. Ноолууран эдлэл	0	7	0%	0	7	0%	0	7	0%	0	7%	0%	(0)	-6%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	0	2	0%	0	3	0%	1	6	0%	1	36%	0%	3	76%	0%
4.4. Уул уурхай	5	11	0%	22	40	2%	12	33	2%	29	259%	1%	(7)	-17%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	2	0%	0	1	0%	0	0	0%	(1)	-57%	0%	(1)	-52%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	42	2%	1	32	1%	1	45	2%	(11)	-25%	0%	13	40%	1%
4.7. Бусад	124	5	0%	108	3	0%	103	4	0%	(2)	-38%	0%	1	31%	0%
5. Бусад		1	0%	1	0%	1	0%	0	33%	0%	(1)	-64%	0%		
Нийт дүн		2,481		2,370		2,193		(110)	-4%		(177.3)	-7.5%			


*2 - Нийтөсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын гадаад худалдааны өөрчлөлт, 2016 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
1. Уул уурхай	419.3	-233%	(599.3)	333%	(180.0)	-9%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	176.5	-78%	(403.1)	178%	(226.7)	-20%
1.2. Чулуун нүүрс	86.1	-642%	(99.5)	742%	(13.4)	-4%
1.3. Боловсруулагүй нефть	15.6	-42%	(52.6)	142%	(37.0)	-19%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	12.0	-75%	(28.1)	175%	(16.1)	-14%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	121.2	99%	1.1	1%	122.3	77%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	12.2	818%	(10.7)	-718%	1.5	2%
1.7. Жоңц, лейцит, нефелинт	(4.3)	96%	(0.2)	4%	(4.4)	-14%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2.5	-40%	(8.6)	140%	(6.1)	-34%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	(0.5)	43%	(0.7)	57%	(1.2)	-23%
1.10. Мөнгө /тонн/	(1.9)	-120%	3.5	220%	1.6	22%
1.11. Бусад	(0.0)	2%	(0.4)	98%	(0.4)	0%
2. Мал аж ахуй	(12.2)	-329%	15.8	429%	3.7	2%
2.2. Арьс, шир	(8.3)	839%	7.3	-739%	(1.0)	-6%
2.4. Ноолуур	(4.9)	-78%	11.3	178%	6.3	4%
3. Газар тариалан	(5.7)	59%	(4.0)	41%	(9.7)	-46%
4. Аж үйлдвэрлэл	(14.1)	-146%	23.8	246%	9.7	10%
5. Бусад	(0.0)	5%	(0.9)	95%	(0.9)	-64%
Нийт дүн	387.3		(564.5)		(177.3)	-7%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2016 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 387.3 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 564.5 сая ам.доллараар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл уул уурхайн түүхий эдийн экспорт тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалан 419 сая ам.доллараар өссөн хэдий ч үнийн бууралтаас шалтгаалж 599.3 сая ам.доллараар буурснаас нийт 180 сая ам.доллараар буурлаа.

МАА-н түүхий эдийн экспорт үнийн өсөлтөөс шалтгаалж 16 сая ам.доллараар өссөн бол тоо хэмжээний бууралтаас шалтгаалан 12 сая ам.доллараар буурсан байна. Харин машин, тоног төхөөрөмжийн экспортын өсөлтөөс голлон шалтгаалж аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 10%-иар буюу 9.7 сая ам.доллараар өсчээ.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны сарын дундаж үнэ 2016 оны 6-р сард 1,264 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7%-иар, өнгөрсөн сараас 1%-иар өссөн байна. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ тайлант сард харгалзан 4,642, 52 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20%-иар, 17%-иар, өнгөрсөн сартай харьцуулахад 1%-иар, 6%-иар тус тус буурсан байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 6 дугаар сард 30 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 29%-иар, өмнөх сараас 3%-иар тус тус буурсан байна.

Импортын гадаад худалдаа 2016 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 18.5%-иар буюу 339.6 сая ам.доллараар буурсан. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 0.4%-ийг, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 10%-ийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 7%-ийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 6 нэгж хувиар өссөн бол нефтийн бүтээгдэхүүний жин 5 нэгж хувиар буурчээ.

Хүснэгт 5. Импортын гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%2	Дүн	Өсөлт	%2
Хэрэглээний бүтээгдэхүүн		692	26%		548	30%		540	36%	(144)	-21%	-5%	(7)	-1%	0%
Түргэн эдэлгээтэй	405	363	44%	362	304	17%	365	280	19%	(59)	-16%	-2%	(24)	-8%	-1%
Хүнс	189	251	10%	183	209	1%	189	192	13%	(42)	-17%	-2%	(17)	-8%	-1%
Эм, тэриа	1	39	1%	1	35	2%	1	42	3%	(3)	-9%	0%	7	19%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	214	73	3%	178	59	3%	175	45	3%	(13)	-19%	-1%	(14)	-23%	-1%
Удаан эдэлгээтэй	86	329	12%	97	244	13%	66	261	17%	(86)	-26%	-3%	17	7%	1%
Гутал, хуцас, цүнх	15	28	1%	21	22	1%	25	23	2%	(5)	-19%	0%	0	2%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба төвөг	40	64	2%	49	50	3%	11	51	3%	(14)	-21%	-1%	1	1%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	199	8%	1	138	7%	0	156	10%	(6)	-31%	-2%	18	13%	1%
Бусад удаан эдэлгээтэй бараа	30	39	1%	26	34	2%	30	31	2%	(6)	-14%	0%	(3)	-8%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн		1,107	42%		685	37%		498	33%	(422)	-38%	-16%	(187)	-27%	-10%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	15	648	25%	9	360	20%	7	279	19%	(287)	-44%	-11%	(82)	-23%	-4%
Судлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	176	7%	1	63	3%	0	72	5%	(113)	-64%	-4%	9	14%	0%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	14	471	18%	9	297	16%	7	207	14%	(174)	-37%	-7%	(90)	-30%	-5%
Барилгын материал	1,340	354	13%	814	240	13%	358	131	9%	(114)	-32%	-4%	(109)	-45%	-6%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	39	105	4%	34	84	5%	22	88	6%	(21)	-20%	-1%	4	5%	0%
Аж үйлдвэрлэлийн орц		290	11%		259	14%		261	17%	(31)	-11%	-1%	2	1%	0%
Хүнсний орц	40	20	1%	27	16	1%	155	41	3%	(4)	-20%	0%	25	155%	1%
Химийн бүтээгдэхүүн	61	47	2%	72	50	3%	62	41	3%	3	7%	0%	(9)	-17%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	12	7	0%	9	8	0%	10	9	1%	1	10%	0%	1	11%	0%
Цахилгаан эрчим хүч	1	57	2%	1	65	4%	1	61	4%	8	15%	0%	(4)	-6%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	0	0%	0	1	0%	1	1	0%	1	327%	0%	(0)	-8%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	455	159	6%	420	120	7%	364	108	7%	(40)	-25%	-2%	(12)	-10%	-1%
Нефтийн бүтээгдэхүүн		504	53%		515	31%		419	19%	(207)	-38%	-8%	(133)	-40%	-7%
Дизель түнш	295	301	11%	289	176	10%	211	90	6%	(125)	-42%	-5%	(85)	-49%	-5%
АИ-92, АИ-95	140	154	6%	170	110	6%	152	72	5%	(44)	-22%	-2%	(38)	-35%	-2%
А-80 болон бусад	69	84	3%	56	45	2%	56	36	2%	(38)	-46%	-1%	(10)	-21%	-1%
Бусад	1	10	0%	11	16	1%	3	2	0%	6	0%	0%	(14)	-1%	-1%
Нийт дүн		2,637		1,839			1,499			(798)	-30.3%		(340)	-18%	


%2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын гадаад худалдааны өөрчлөлт, 2016 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(51.6)	708%	44.3	-608%	(7.3)	-1%
Түргэн эдэлгээтэй	(6.5)	27%	(17.6)	73%	(24.1)	-8%
Удаан эдэлгээтэй	(45.1)	-267%	61.9	367%	16.9	7%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	(261.4)	140%	74.6	-40%	(186.8)	-27%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	(106.3)	130%	24.7	-30%	(81.6)	-23%
Барилгын материал	(107.9)	99%	(1.3)	1%	(109.2)	-45%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(47.3)	-1177%	51.3	1277%	4.0	5%
Аж үйлдвэрлэлийн орц	11.7	740%	(10.1)	-640%	1.6	1%
Нефтийн бүтээгдэхүүн	(42.3)	32%	(90.7)	68%	(132.9)	-40%
Дизель түнш	(33.2)	39%	(52.1)	61%	(85.3)	-49%
АИ-92, АИ-95	(8.4)	22%	(29.7)	78%	(38.1)	-35%
А-80 болон бусад	(0.6)	7%	(8.9)	93%	(9.5)	-21%
Бусад	1.3	-9%	(15.4)	109%	(14.2)	0%
Нийт дүн	(342.3)		2.7		(340)	-18%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



Тойм тооцооллоос үзэхэд 2016 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр импортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс голлон шалтгаалж нийт дүнгээр 339.6 сая ам.доллараар буурчээ.

Бүлэг тус бүрээр авч үзвэл хэрэглээний бүтээгдэхүүний импорт автомашины импортын үнэ нэмэгдсэнээс шалтгаалан өссөн хэдий ч, тоо хэмжээ буурснаар уг бүлгийн импорт 7.3 сая ам.доллараар буурчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 27%-иар буюу 186.8 сая ам.доллараар буурсан нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ болон үнэ зэрэг буурснаар уг бүлгийн импорт 40%-иар буюу 132.9 сая ам.доллараар буурчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос эхлэн тогтмол буурч байна. Хилийн үнэ 2012 оны 12 сард тонн тутамд 1,270.5 ам.доллар байсан бол 2016 оны 6-р сарын байдлаар тонн тутамд 489.7 ам.долларт хүрээд байна.